

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
С.Одонтуяа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд хүүхэд хамгааллын зарчим, төрийн чиг үүргийг тодорхойлж, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох, нийгэм, гэр бүлийн хүрээнд хүүхдийг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар тусгажээ.

Хуулийн төсөл батлагдсанаар хүүхдийн эрхийн баталгаа хангагдаж, хүүхэд хамгааллын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагын чиг үүргийг оновчтой болгох, хүүхэд хамгааллын мэргэшсэн ажилтан бэлтгэх, хүүхэд бүрт чанартай, хүртээмжтэй үйлчилгээг хүргэх зэрэгт ач холбогдолтой гэж үзсэн байна.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр хүүхдийг хүмүүжүүлэх монгол уламжлалт арга, соён гэгээрүүлэх асуудлыг түлхүү оруулах, хуулийн төслийн зарим үг хэллэг, найруулгын алдааг засч сайжруулах, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхихыг хориглох, малчин өрхийн хүүхдийн сургуульд элсэн суралцах насыг сонголттой болгох, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан хүүхдэд ээлтэй, таатай орчинг бүрдүүлэх олон улсын туршлагыг судлах, Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазар монгол ухаан, ёс заншилд тулгуурлан хүүхдийг хүмүүжүүлэх, бага насны хүүхдийг шашны үзэл суртлаас ангид байлгах зэрэг саналуудыг тус тус гаргалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ